

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨВ АЛТАЙ ХОТОД БАРИГДАХ 25 ГКАЛЦ ХУЧИН
ЧАДАЛТАЙ ДУЛААНЫ СТАНЦ, 4816 М ШУГАМ ХООЛОЙ, 6 ТҮГЭЭХ ТӨВҮҮДИЙГ
БАРЬЖ АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5638089/

ХЯНАСАН:

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

.....

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“БЬЮКСАН ИНЖЕНЕРИНГ”
компаний захирал ЧОЙ САНГ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“БЬЮКСАН ИНЖЕНЕРИНГ” компанийн
ХАБЭАБО хариуцсан менежер А.АНДБАЯР

ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Говь-Алтай аймгийн Алтай хотод баригдах 25 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, 4816 метр шугам хоолой, дулаан дамжуулах 6 төвийг барьж ашиглах төслийг “Энерготех Сервис” ХХК компани гүйцэтгэж байна.

Говь-алтай аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн ажлын гүйцэтгэгч “Энерготех Сервис” ХХК нь төслийн талбайд 2023.04 сард эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд доорх ажлуудыг гүйцэтгээд байна.

2023 оны 05 -р сарын 1 –нээс барилгын суурийн ажил, конвейер I, II, бутлуурын барилгын суурийн ажлууд эхэлсэн.

Конвейер I, II , бутлуурын барилга, харуулын байрны суурь, түлш хүлээн авах барилга, утаа сорогчийн барилгын суурь, цахилгааны барилгын суурь зэрэг үндсэн барилга угсралтын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зуух угсралтын ажил нь 2023 оны 04 -р сард эхэлсэн. Одоогийн байдлаар зуух 1,2,3-ын экран хоолой, циклон, эканомайзер, агаар халаагч зэрэг тоноглолуудыг угсарч дуусаад байна.

2023 онд төслийн гүйцэтгэл

Барилга угсралт 25 %

Зураг төсөв 70 %

Тоног төхөөрөмж ханган нийлүүлэлт 60 %

Нийт гүйцэтгэл 42 % тай явж байна.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд “Энерготех Сервис” ХХК-ийн зүгээс доорх үндсэн чиглэлийг голлон хэрэгжүүлэн ажиллалаа.

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд
- Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд
- Хог хаягдлын менежментийн хүрээнд
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

2018 онд батлагдсан 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан байгаль орчны бүрдэл хэсгүүд бүрт тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, үндэслэл, баримтлан ажиллах дүрэм, стандартууд, зардлын хамт оруулсныг мөрдөж ажилласан.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Дулааны станцын барилгын ажилд ашиглаж байгаа бараа материал, тоног төхөөрөмжийн сав, баглаа, боодол, материалын ашиглахгүй болсон хэсэг, ажиллагсадын ахуйн гаралтай хол хаягдлаар газрын гадарга бохирдож болзошгүй.	Барилгын талбайд хог хаягдал хадгалах түр хогийн цэг байгуулсан. Хог хаягдлыг зориулалтын тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт хүргэж хаяж байна.	Төслийн хугацаанд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт багтсан	ХАБЭАБО алба
Барилгын ажлын үед ашиглаж байгаа тээврийн хэрэгслээс тос, шатахуун асгарч газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй.	Төслийн талбайд зогсоол байгуулж тээврийн хэрэгслийг байрлуулж байна. Төслийн талбайд автомашины засвар үйлчилгээ хийхийг хориглосон. Хэрэв ШТМ асгарсан тохиолдолд саарамгжуулах арга хэмжээг хурдан шуурхай авч хэрэгжүүлнэ.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
Дулааны станц, дулаан дамжуулах шугам болон дулаан дамжуулах төвүүдийг барих явцад нийт 2.33 га талбайгаас нийт 0.4 тн ялзмагийн нөөц бүхий 3495 м ³ үржил шимт хөрс хуулагдаж, эвдэрнэ.	Барилгын ажил эхлэхийн өмнө хуулж авсан шимт хөрсийг овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтийн ажилд эргүүлэн ашиглахаар хадгалж байна.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба

Барилгажилтын үе: Жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн нүх, оромж нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгажилтын явцад амьтад устахаас урьдчилан сэргийлж, газар хөндөлтийн өмнө амьтад өртөх эсэхийг шалгах, амьтдыг эрсдэх орчноос үргээж холдуулах ажлыг хийсэн.		Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
Дүн				

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Ахуйн хатуу хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан хогийн цэг байгуулан түр хадгалж байна.	Төслийн хугацаанд		-ХАБЭАБО алба
Ахуйн хог хаягдлыг тогтоосон хугацаанд нь тээвэрлүүлэх	Алтай хотын тохижилт үйлчилгээний газартай хийсэн гэрээний дагуу 7 хоногт 3 удаа зөөвөрлөн хаяж байна.	7 хоног бүр	950.000	-Алтай хотын ОНӨААТҮГ -ХАБЭАБО алба
Газрын доорх усны чанар нөлөөлж болзошгүй хөрс бохирдуулахгүй байх, Хэрэглээнээс гарсан бохир усыг зориулалтын танканд хуримтлуулан татан зайлуулах.	Хэрэглээнээс гарсан бохир усыг Ундарга- Алтай ААТҮ газартай гэрээ байгуулж татан зайлуулж байна,	7 хоног бүр	600.000	-Ундарга- Алтай ААТҮГ -ХАБЭАБО алба
Дүн			1.500.000	

НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Төслийн хувьд барилга угсралтын ажил нийтдээ 25,6 сарын турш үргэлжлэн, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн тул нөхөн сэргээлт, орчны тохижилттой холбоотой ажлуудыг 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаагүй учраас нөхөн сэргээлт, орчны тохижилтийн ажил 2023 онд хийгдээгүй.

Барилгын ажлын явцад болон дууссаны дараа нөлөөлөлд өртсөн газрыг тэгшилж, дулааны станцын барилга хоорондын талбайг тохижуулах, хөрс хуулалтаас хадгалсан өнгөн хөрсөөр ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн сэргээлт, орчны тохижуулалт болон явган хүний зам, автозамыг хатуу хучилттай болгох ажил хийгдэнэ.

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Судалгааны хүрээнд тус аймагт дулааны станцын төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох айл өрх, хувь хүн, аж ахуйн нэгж байхгүй болно.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд аймаг, сум, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага хүргүүлээгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гараагүй.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Говь-Алтай аймгийн Алтай хотод баригдах дулааны станцын төслийн үйл ажиллагаанд хамаарах талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар, археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй гэсэн үүрэг хүлээн ажиллаж байна.

ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

Төслийн бүхий л үе шатанд учирч болзошгүй аюул, осол эрсдлүүдийг урьдчилан тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажиллаж байна.

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, боломжит бүх арга хэмжээг авах, Нийт ажилчдыг гал унтраах сургалтад хамруулах, Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах, Төслийн талбайд галын дохиолол, аюулын гарц байрлалыг заасан самбар байрлуулах, галын дохиолол, гал унтраах хэрэгслийн тэмдэг санамж байрлуулах,	Галын аюулгүй байдлыг хангаж MNS 5566:2020 стандартын дагуу В ангиллын галын хор, галын сарайг хийж байршуулсан. Мөн төслийн барилгын шаардлагатай газруудад галын хор байршуулсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, анхааруулах, санамж тэмдэг, самбаруудыг барилгын талбайд байрлуулсан.	Төслийн хугацаанд	600.000	ХАБЭАБО алба
Төслийн талбайд аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон аюултай бодистой холбоотой бусад бүх журмыг дагаж мөрдөх	Төслийн талбайд аюултай бодистой холбоотой бүх дүрэм журмыг мөрдөж, гэсэрч дэлбэрэх аюултай хийн баллонуудыг зориулалтын хадгалах саванд хийн аюулгүй байдлыг хангасан. Бусад бүх журмыг дагаж мөрдөн ажиллаж байна.	Төслийн хугацаанд		ХАБЭАБО алба
Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх	Яаралтай үед ашиглах анхны тусламжийн хайрцагийг байршуулж, шаардлагатай эм, тариа бусад хэрэглэлүүдээр хангасан. Энх-Алтай ӨЭМ төвтэй хамтарч ажиллах гэрээ байгуулан ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.	Төслийн хугацаанд	1.050.000	Энх-Алтай ӨЭМТ ХАБЭАБО алба

Автомашинны осол	Автомашинны осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлж тээврийн хэрэгслийн авто зогсоол байгуулсан. Барилгын ажлын үед зорчих замыг засч замын хөдөлгөөний дүрмийн дагуу тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
Ажиллагсдын эрүүл мэнд	Ажиллагсдыг хүнс болон хэрэглээний усны чанарт анхаарч эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усыг хэрэглэж байна. Хэрэглээний цэвэр усыг 2023 оны 5 сард Говь-Алтай аймгийн стандарт хэмжил зүйн итгэмжлэгдсэн лабораторид нян судлал, хими, хор судлалын шинжилгээнд хамруулсан.	Жилд 1 удаа	Орчны хяналт шинжилгээний зардалд багтсан	ХАБЭАБО алба
Дүн			1.650.000	

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

“ Энерготех Сервис ” ХХК-ийн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлж буй дулааны станц барьж ашиглах төслийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2023 оны БОМ-н төлөвлгөөний дагуу хөрс, агаар, тоосны, шинжилгээг жилд 1 удаа авч Говь-Алтай аймгийн УЦУОШ газрын лабораторт, ундны уснаас хагас жил тутам дээж авч итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж байнгын хяналт тавин ажиллаж байна.

Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Хөрс				
Ерөнхий хими болон элементийн шинжилгээ	Говь-Алтай Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газарт төслийн барилгын талбайн 2 цэгээс дээж авч хөрсний шинжилгээ хийлгэсэн.	2023/05 сард	250.000	Говь-Алтай аймгийн УЦУОШ Газар ХАБЭАБО
Дүн			250.000	төгрөг
Ус				
Усны ерөнхий химийн шинжилгээ	Говь-Алтай аймгийн стандарт хэмжил зүйн итгэмжлэгдсэн лабораторт усны шинжилгээ өгсөн.	1 удаа	80.000	Говь-Алтай аймгийн хэмжил зүйн лаборатори ХАБЭАБО
Хүнд элементийн шинжилгээ				
Бактериологийн шинжилгээ				
Дүн			80.000	төгрөг
Агаар				
Тоос PM10, PM2.5	Говь-Алтай Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газарт дээж авч агаарын шинжилгээ хийлгэсэн.	2023.05 сард	250.000	Говь-Алтай аймгийн УЦУОШ Газар ХАБЭАБО
Дуу чимээ				
Дүн			250.000	төгрөг
Нийт дүн			580.000	төгрөг

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ТАЙЛАН

№	Менежментийн төлөвлөгөөний зардлын агуулга	Зарцуулсан зардлын хэмжээ, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	1.500.000
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	1.650.000
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	580.000
Нийт		3.730.000

ДҮГНЭЛТ

Говь-Алтай аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл эхэлснээс хойш аюул осолгүй, байгаль орчинд ээлтэй ажилласан байна. Энэ хугацаанд байгаль орчны эсрэг гарсан үл тохирол, зөрчилгүй ажилласан.

БОМ- н төлөвлөгөө боловсруулснаар хүн болон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг цаг алдалгүй хариу арга хэмжээ авч аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

- Байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.
- Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Байгаль орчны тухай хууль тогтоомжыг мөрдүүлэн ажиллаж байна.

Алтай хотын тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

БАТЛАВ

АЛТАЙ ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ *Бат-Орших* Ц.БАТ-ОРШИХ

ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023..оны 07 дугаар..сарын 23 өдөр

Дугаар

Алтай хот

Монгол улсын "Татварын ерөнхий хууль" "Хог хаягдлын тухай хууль" "Ариун цэврийн тухай" хууль, Есөнбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 07 тоот тогтоолоор шинэчлэн баталсан хог хаягдлын үнэ тариф /татварын хураамж/ Алтай хотын тохижилт ариун цэврийг сайжруулах талаар дагаж мөрдөх журмыг үндэслэн:

Нэг талаас; Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын *Батцэнхэр* багийн нутаг дэвсгэрт байрлах *"Хог хаягдал тээвэр" ХХК* байгууллага, аж ахуйн нэгжийг төлөөлж *Х.Д.Э.О. Шинэчлэл* ажилтай *М.Шинэчлэл* овогтой *Бат-Орших* гэр нь цаашид /үйлчлүүлэгч гэх/

Нөгөө талаас: Алтай хотын тохижилт үйлчилгээний газар Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын *Бат-Орших* ажилтай *Урвагчил* овогтой *Б.Орших* нар нь харилцан тохиролцож 2023 оны 07 дүгээр сарын 23-ны өдрөөс 2024 оны 07 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал тухайн байгууллагын байгаль орчин бохирдуулж энгийн хог хаягдал гаргасан хэмжээнээс хамаарах үнэ тариф /татварын хураамж/-ыг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх, энгийн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн үйлчлүүлэхээр дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

Үйлчлэгч байгууллага

1. Үйлчлэгч байгууллага нь өөрийн техник, нөөц бололцоо, ажлын онцлогоос шалтгаалан үйлчлэгч байгууллагын хог хаягдлыг тээвэрлэн зайлуулах хуваарийг гаргаж Есөнбулаг сумын Засаг даргаар батлуулж мөрдлөг болгон ажиллана.
2. Байгууллага, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг ажлын ачаалал, техникийн бололцооноос хамааран долоо хоногт 1-2 удаагийн давтамжтай тээвэрлэнэ.
3. Байгаль орчин бохирдуулж энгийн хог хаягдал гаргасны үйлчилгээний үнэ тариф /татварын хураамж/-ыг "Хог хаягдлын тухай хууль"-ийн 9.2.1, 9.2.2,

Алтай хотын тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

“Татварын ерөнхий хууль”-ийн 7.2.23 д заасны дагуу сумын ИТХ-ын тогтоолоор баталсан үнэ тариф /татварын хураамж/-ыг дагуу хураан төвлөрүүлнэ.

4. Хог хаягдалтай холбоотой дуудлагыг 70483538 тоот утсанд ажлын 8 цагаар авч ажиллана.

Үйлчлүүлэгч байгууллага

1. Үйлчлүүлэгч хог тээврийн машин очих үед хог хаягдлаа савлан /тусгай уутанд хийж тавих/ ба ачуулсан тэмдэглэлээ он, сар, өдөртэй нь өөрийн байгууллагын жижүүрийн дэвтэр болон жолоочийн дэвтэрт гарын үсэг зурж тэмдэглэл хийх

2. Есөнбулаг сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа албан газар аж ахуйн нэгжүүд нь хог хаягдлын тухай хуулийн 9.4.12 / нутаг дэвсгэрийнхээ хог хаягдал цас мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар хамаарагдана/ Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3 /өөрийн өмч эзэмшил ашиглалтанд байгаа газар болон орчны 50 метр хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх /13.1.6 /энэ хуулийн 4.4.3-т заасан нийтийн эзэмшлийн зам, талбайн хог хаягдал, тогтоол ус, цас, мөсгүй байлгах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шат хашлага хайсыг бүрэн бүтэн байлгах / зэрэг заалтууд/-ыг үндэслэн гэрээг хийнэ.

3. Байгаль орчин бохирдуулж хог хаягдал гаргасны үйлчлгээний төлбөрийг “Хог хаягдлын тухай хууль”-ийн 41.1, 41.5 “Татварын ерөнхий хууль”-ийн 7.2.23 -д заасны дагуу гаргасан хог хаягдлын хэмжээнээс хамааран сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 03 сарын 03-ны өдрийн 07-р тогтоолоор баталсан үнэ тарифын дагуу сараар болон дуудлагаар /доогуур зурах/ төлнө. Хог хаягдлын үйлчилгээний хураамж /татварын хураамж/-ийг орон нутгийн орлогын “Төрийн сан” банкны 5337498778 тоот дансанд төлнө.

1. 30,000 төгрөг / *гурим цонгол тугад* /

Үсгээр

/Үнэ тарифын өөрчлөлт гарсан тохиолдолд тухайн үед гарсан тогтоол шийдвэрийн хамт албан тоотоор харилцагч байгууллагад мэдээлэх болно./

4. Ажил үйлчилгээ явуулж байгаа албан газар, аж ахуйн нэгжүүдийн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж /татварын хураамж/-ийг сар бүр мессэжээр дансны дугаартай илгээж байна. Үүний үндсэн дээр татварын цахим хаягаар нэхэмжлэлийг илгээж нэхэмжлэх бичигдсэнээс хойш төлөгч байгууллага 7 хоногийн дотор төлнө.

5. Хог хаягдлыг дуудлагаар ачиж тээвэрлэсэн тохиолдолд орлогын байгцаагчид мөнгө хураасан жагсаалтан дээр 2 талын гарын үсэг зурж баталгаажуулан хийж гүйцэтгэнэ. Мөн үйлчлэгч байгууллагын хог хаягдлын үйлчилгээний /татварын

Алтай хотын тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

хураамж/ орлогыг сар бүр төлөх дүнгээр нь "QR" кодыг татварын сайтаас үүсгэн авч төлөгч багууллагад илгээнэ.

6. Тухайн байгууллага нь байгаль орчин бохирдуулж энгийн хог хаягдал гаргасны төлбөр /татварын хураамж/-аа сар бүр төлж дуусгавар болгосны дараа үйлчилгээгээ авна. Хугацаандаа төлөөгүй байгууллагын төлбөр /татварын хураамж/-аас алданги тооцож авах ба цаашид үйлчилгээгээ үзүүлэхийг цуцална.

7. Гэрээний нөхцөлийг зөрчсөн тухай аль нэг талын санал гомдлыг Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газарт гаргана.

8. Гэрээний нэмэлт.....

Энэхүү гэрээ нь нийт 3 (гурав) хуудас бөгөөд монгол хэл дээр 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ҮЙЛЧЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
АЛТАЙ ХОТЫН ТОХИЖИЛТ

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
Говь-Алтай, Есөнбулаг сум
Дулааны станц Барилга угсралтын
Ажлыг гүйцэтгэгч Энерго Тех
Сервис ХХК
Инженер М. Баярсайхан

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗОХИЦУУЛАГЧ Ц.Сувд-Эрдэнэ
Говь-Алтай, Есөнбулаг, Оргил баг
Утас: 70483538, 99583163



Алтай хотын “УНДАРГА-АЛТАЙ” ААТҮГ-тай байгуулсан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ

БАТЛАВ
“УНДАРГА-АЛТАЙ” ААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ: Э.ЭНХБОЛД

ЦЭВЭР УСААР ХАНГАХ, ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УСЫГ ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2023 оны 08 сарын 23

Хэрэглэгчийн бүртгэл №.....

Нэг талаас “Ундарга-Алтай” ААТҮГ-ыг төлөөлж *М.Сүрэн*... *А.В.С.* ажилтай *Э.Энхболд* цаашид /хангагч/ гэх нөгөө талаас *Цыгэмт* *Манаа* *Бүт*... төлөөлж *М.Сүрэн*... *А.В.С.* ажилтай *Э.Энхболд* цаашид /хэрэглэгч/ гэж нэрлэгдэх нар 2023 оны 08 сарын 23-д өөрсө эхлэн дор дурдсан нөхцөлийг бие биэлд ажлахаар тохиролцон хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага /хангагч/ болон үйлчилгээг хүртэж буй байгууллагууд /хэрэглэгч/-ийн хоорондын харилцаа, гэрээ байгуулах нөхцөл, түүнд тавих шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцөл зэрэг харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хангагчийн эрх, үүрэг

2.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6 дах хэсэгт заасны дагуу батлагдсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “MNS 0900:2005 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” ундны усны стандартын шаардлагад нийцсэн усаар хангах үүрэгтэй.

2.2 Хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон шугам сүлжээ, барилга байгууламжид хяналт тавьж, хэрэглэгчид ашиглалтын талаар мэргэжлийн тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх үүрэгтэй.

2.3 Хэрэглэгчийн зүй бус усны хэрэглээг илрүүлэх, усны алдагдлыг таслан зогсоох, усыг хэмнэлттэй хэрэглэх бодлого баримтлах, хэрэглэгчийн нийлүүлж буй бохир усанд лабораторийн шинжилгээ хийж, байнгын хяналт тавих үүрэгтэй.

2.4 Хангагч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хэмжээг баримтлан үйлдвэрлэл явуулж буй хэрэглэгчийн технологийн хэрэглээнээс гарч буй бохир уснаас сар бүр дээж авч шалгах эрхтэй.

2.5 Эрх бүхий байгууллагаас усны үнэ тарифт нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд түүнийг мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах үүрэгтэй.

2.6 Хууль тогтоомж буюу гэрээг санаатайгаар зөрчиж цэвэр, бохир усны шугамд зөвшөөрөлгүй холбосон бол тухайн ус хэрэглээний тооцоог шугам угаалга, дүүргэлтийг тооцох аргачлалаар бодож тогтоон нөхөх төлбөр төлөхийг шаардах эрхтэй. /Шугам дүүргэлт, угаалга тооцох аргачлалаар бодож тогтоохдоо урсгалын хурдыг 1.5 м/с гэж үзэж, хоолойн хөндлөн огтлолын талбайгаар тооцно/.

2.7 Хэрэглэгчийн эзэмшлийн ариутгах татуургын шугам сүлжээнд хур тунадасны ус оруулсан тохиолдолд нийлүүлсэн усны хэмжээг шугамын дүүргэлтийг 100% , урсгалын хурдыг 1.0 м/с байхаар төлбөрийг тооцоолж, хэрэглэгчээр төлүүлэхээр шаардах эрхтэй.

2.8 Хэрэглэгч усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар ашиглаж байгаа нь тогтоогдвол уг зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгөх, мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж хариуцлага тооцуулах, гэрээг цуцлах эрхтэй.

2.9 Хэрэглэсэн цэвэр ус, нийлүүлсэн бохир усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчдийг цэвэр усаар хангахгүй байх, гэрээг цуцлах эрхтэй.

2.10 Хэрэглэгчийн буруугаас ус хангамж, ариутгах татуургын системд гэмтэл гаргасан тохиолдолд учирсан хохирлыг барагдуулахыг хэрэглэгчээс шаардах эрхтэй.

2.11 Хүндэтгэн үзэх шалгаангүйгээр үйлчилгээний төлбөр тооцоогоо цаг хугацаанд нь төлөөгүй буюу хугацаа хэтэрсэн тохиолдолд хангагч байгууллагын зүгээс хэвлэл мэдээлэлээр нийтэлж хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5%-иар бодож алданги тооцно.

Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

3.1 Хангагчтай байгуулсан гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, хангагчийн эрх бүхий тушаалтныг сар бүр усны тоолуурын заалт авах боломжоор хангах, баталгаажуулах, төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

3.2 Хэрэглэгч өөрийн эзэмшлийн цэвэр, бохир усны шугам, худгийн бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавьж, стандартын тагтай байлгах ба техникийн өрөө, зоорийн давхрыг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

3.3 Өөрийн зааг эзэмшилд байгаа ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ барилга байгууламжийг гэмтээхгүй, усанд автуулахгүй, хөлдөөхгүй байлгах, худгийн тагийг цас мөснөөс цэвэрлэх, хангагч байгууллагаас тавьсан лац, ломбыг гэмтээхгүй байх, гадаргуугийн болон хур тунадасны ус зайлуулах сувгийг

Алтай хотын “УНДАРГА-АЛТАЙ” ААТҮГ-тай байгуулсан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ

ариутгах татуургын шугам сүлжээнд холбохгүй байх, галын гидрантын ашиглалтын бүрэн бүтэн байдал хангах, ус зөөвөрлөх боломжтой орц гарцтай байх зэрэг хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

3.4 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид гарсан осол гэмтлийн талаар хангагч байгууллагад яаралтай мэдэгдэж, хангагчийн төлөөлөл ирэх хүртэл гарсан хэсгийг хяналтандаа байлгана.

3.5 Хэмжих хэрэгслийн зангилааг барилгын норм ба дүрмийн дагуу үзлэг, үйлчилгээ хийхэд тохиромжтой, ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгтэй, +5°C-ээс доошгүй хэмтэй өрөөнд буюу дулааны үзэлийн өрөөнд байрлуулна.

3.6 Усны тоолуурыг холбогдох журмын дагуу хэрэглэгч өөрийн хөрөнгөөр суурилуулах бөгөөд ашиглалт, үйлчилгээг хариуцна.

3.7 Хэрэглэгчийн усны тоолуур гэмтсэн тохиолдолд хангагчид мэдэгдэж, засварлуулах арга хэмжээг авах үүрэгтэй.

3.8 Хэрэглэгч усны нөөц тоолууртай бол хангагчийн төлөөлөгчийг байлцуулан сольж, заалтыг 2 тал баталгаажуулна.

3.9 Хэрэглэгчийн усны хэрэглээг үндэслэлгүй, огцом өөрчлөгдсөн тохиолдолд хэмжих хэрэгслийн зангилааг хангагчтай зөвшилцөн зөрчлийг арилгуулна.

3.10 Хэрэглэгч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зөвшөөрөгдөх хэмжээнд нийцсэн бохир усыг төвлөрсөн шугамд нийлүүлнэ.

3.11 Худяг, камерийн бүрэн бүтэн байдал хяналт тавьж, гадны хүн оруулахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

3.12 Хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд өөр хэрэглэгчийг холбох бол зөвхөн хангагчийн зөвшөөрлөөр холбож, эрх бүхий ажилтны хяналтан дор холболтыг гүйцэтгэнэ.

3.13 Хэрэглэгч хангагчийн эрх бүхий ажилтанд ус түгээгүүрийн оруулга, усны тоолуурын зангилаа, сантехникийн хэрэгсэл/ванн, тосгуур, угаагуур, жорлон/-ийг шалгах бололцоогоор хангана.

3.14 Өөрийн эзэмшлийн шугам сүлжээнд хангагчтай зөвшилцөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбох, тэдгээртэй усаар хангах аж ахуйн гэрээ байгуулахыг хориглоно.

Дөрөв. Усны үйлчилгээний төлбөр тооцоо

4.1 Цэвэр, бохир усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

Хэрэглэгч худалдан авсан цэвэр ус, нийлүүлсэн бохир усны төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дах хэсэгт заасны дагуу хангагч нь алданги тооцох эрхтэй.

4.2 Усны хэрэглээний төлбөрийг Монгол Улсын стандартад нийцсэн, эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тоолуурын заалтаар тооцох бөгөөд тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.2-д зааснаар тооцно.

4.3 Хэрэглэгч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчийг тоолуурын заалт авах боломжоор хангаагүй мөн тоолуурын заалт тохиолдолд хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээг сүүлийн 3 сарын дунджаар, шинээр холбогдсон хэрэглэгчийн хувьд хэрэглэсэн усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.2-д зааснаар, тоолуургүй хэрэглэгчийн тарифаар тооцно.

4.4 Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэгдэж байгаа бохир усны хэмжээг тооцохдоо цэвэр усны хэрэглээг үндэслэнэ.

4.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасны дагуу батлагдсан цэвэр, бохир усны үнэ, тарифыг дагаж мөрдөнө


4.5.1 Төсөвт байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага/НӨАТ-гүй/

Ангилал	Хэмжих нэгж		Тариф
Төсөвт байгууллага	Цэвэр	төг/л	13.00
	Бохир	төг/л	11.00
Үйлдвэр ААНБ	Цэвэр	төг/л	5.00
	Бохир	төг/л	4.00
Зөвөрөөр	Цэвэр	төг/л	15.00
	Бохир	төг/л	15.00
Зөвөрөөр/өөрийн машинаар/	Цэвэр	төг/л	5.50
	Бохир	төг/л	-

4.5.2 Төсөвт байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага/НӨАТ-гүй/

	Оролтын шугамын голч /мм/	Суурь хураамж цэвэр	Суурь хураамж бохир
1	15	3600	1000
2	20	4960	1200
3	25	7600	1800
4	32	11200	2700
5	40	16720	4000
6	50	25680	6400
7	65	32640	7900
8	80	44260	10500
9	100	65600	15280
10	150	104400	25200
11	400=<	384000	76800

Усны шинжилгээний хариу



Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лавлагаа Лабораторийн
ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН

ЛАБОРАТОРИ

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, 10-р баг, Оргил
Утас: 70483396 Факс: 70483396

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар /Registration number/ : 23-71

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : Энерготех сервис ХХК

/The name of customer's request for analysis/

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/ : Эрүүл ахуйн хими, хор судлалын
хяналтын лаборатори; Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори

Дээжийн тодорхойлолт /Sample description/					
Дээжийн дугаар Sample number	Дээжийн нэр Name of sample	Цувралын дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer	Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry	Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample
131	Ундны ус		Монгол Улс	Тодорхойгүй	1,5 л

Хүлээн авсан огноо Date of receipt	Шинжилгээ дууссан огноо Date of test completion	Хэвлэсэн огноо Date of issue of the report
2023 он 05 сар 25 өдөр	2023 он 05 сар 26 өдөр	2023 он 05 сар 26 өдөр

Дээжийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter and unit	Шаардлага Test specification, unit	Шинжилгээний дүн Test results	
131	MNS ISO 4428:1997	Аммоний	1,5 мг/л	0,0 мг/л	
	MNS 4335:1996	Кальций	100,0 мг/л	1,0 мг/л	
	MNS 4341:1996	Магний	30,0 мг/л	16,0 мг/л	
	MNS 4430:2005	Нийт төмөр	0,3 мг/л	0,0 мг/л	
	MNS ISO 7890-3:2001	Нитрат	50,0 мг/л	0,0 мг/л	
	MNS 4431:2005	Нитрит	1,0 мг/л	0,0 мг/л	
	MNS ISO 10523:2001	pH	6,5-8,5	8,0	
	MNS 6271:2011	Сульфат	500,0 мг/л	0,0 мг/л	
	MNS ISO 8467:1999	Фосфат	3,5 мг/л	0,0 мг/л	
	MNS ISO 8059:2001	Хатуулаг	7,0 мг*эвс/л	2,6 мг*эвс/л	
	MNS 4424:2005	Хлорид	350,0 мг/л	64,0 мг*эвс/л	
	MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар	1,0 мСм/см	0,846 мСм/см	
	САЗ ХХСЛ.4.1.009	Нийт эрдэсжилт		532 мг/л	
	ХХСЛ 4.1.009 САЗ	Давсжилт		0,4 ppt	
	MNS ISO 6222:1998	ББЕТ		1мл-т 100-с ихгүй	1мл-т 30
	MNS ISO 19250:2017	Salmonella spp		100мл-т илрэхгүй	25г-д илрээгүй
MNS ISO 9308-1:1998	Escherichia coli		100мл-т илрэхгүй	25г-д илрээгүй	

Санал тайлбар:

Opinions and interpretation

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН
Approved by ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ:

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамардаг.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуульчлахыг хориглоно.



/Ч.БУЯНЖАРГАЛ/

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ

Батлав:
 “Энерготех Сервис” ХХК-ийн
 Ерөнхий инженер Э.Ганхуяг
 Утас: 99191211
 Мэйл хаяг: info@energotech.mn

Батлав:
 “Энх-Алтай” ӨЭМТ-н
 дарга О.Биндэръяа
 Утас: 99723300
 Мэйл хаяг: Oidovbinderaa@gmail.com

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

20... оны ... дугаар
 сарын ...-ны өдөр

Дугаар ...

Алтай хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Нэг талаас “Энерготех Сервис” ХХК /цаашид “А” тал гэх/ түүнийг төлөөлж ХХК-ний ерөнхий инженер Э.Ганхуяг Улсын бүртгэлийн дугаар...^{25.06.517}... нөгөө талаас “Энх –Алтай” ӨЭМТ-ийн дарга Улсын бүртгэлийн дугаар...^{000.233.077} /цаашид “Б” тал гэх/ нар /цаашид хамтад “талууд” гэх/ харилцан тохиролцож, Монгол Улсын Үндсэн хуулийн болон холбогдох бусад хууль эрх зүйн актыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

1.2. Гэрээний талууд нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлийг үндэслэн
Эмнэлгийн анхан шатны тусламжийг хүргэх чиглэл,
 хэлбэрээр хамтран
 ажиллана.

1.3. Хамтын үйл ажиллагааг гэрээний салшгүй хэсэг болох “Хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд /Хавсралтаар батална/ зааснаар хэрэгжүүлнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Гэрээний ерөнхий хугацаа нь 2 жил байна.
- 2.2. Гэрээний эхлэх хугацаа: 20²³ оны ⁰⁷ дугаар сарын 06.-ны өдөр.
- 2.3. Гэрээний дуусах хугацаа: 20²⁴ оны ⁰⁷ дугаар сарын 06.-ны өдөр.
- 2.4. Талууд гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг энэхүү гэрээний 2.3-т заасан хугацаа дуусахаас 1 сарын өмнө харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ

Гурав. Хамтын ажиллагааны удирдлага, хяналт

3.1. Энэхүү гэрээний 1.2-т заасан чиглэл, хэлбэрийн хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг..... Гэрээнд заасны дагуу "А" тал удирдан зохион байгуулна.

3.2. Хамтын үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлж буй "Б" тал нь гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1. "А" талын эрх үүрэг:

4.1.1. хууль буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаас шаардах эрхтэй.

4.1.2. нөгөө талаас хамтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн, бодитой, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр авах эрхтэй.

4.1.3. гэрээг байгуулах үеийнхээс нөхцөл байдал өөрчлөгдөж, анх гэрээгээр тохирсон зохицуулалт нь цаашид боломжгүй болсныг баталж байгаа бол тухайн гэрээний агуулгыг өөрчлөгдсөн харилцаанд тохируулахыг шаардах эрхтэй.

4.1.4. хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон газар, хугацаанд нь зохих ёсоор, шударгаар гүйцэтгэх үүрэгтэй.

4.1.5. гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бөгөөд үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол гэрээнээс татгалаах эрхтэй.

4.2. "Б" талын эрх үүрэг:

4.2.1. нөгөө талаас хамтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн, бодитой, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр авах эрхтэй.

4.2.2. гэрээг байгуулах үеийнхээс нөхцөл байдал өөрчлөгдөж, анх гэрээгээр тохирсон зохицуулалт нь цаашид боломжгүй болсныг баталж байгаа бол тухайн гэрээний агуулгыг өөрчлөгдсөн харилцаанд тохируулахыг шаардах эрхтэй.

4.2.3. хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон газар, хугацаанд нь зохих ёсоор, шударгаар гүйцэтгэх үүрэгтэй.

Тав. Нууцлал хадгалах

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ

5.1. Талууд нь хамтын үйл ажиллагааны явцад олж авсан нөгөө талын байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй бөгөөд хугацаагүйгээр нууцлах үүрэгтэй.

5.2. Талууд гэрээний үүргээ биелүүлэх явцад олж авсан мэдээ, мэдээллийг бусдад задруулсан, мэдээлсэн, хувилсан, дамжуулсан буюу эдгээр үйлдлийг хийхийг завдсан нөхцөлд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Эрүүгийн хууль болон холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. "Б" тал хэрэгжүүлж буй хамтын үйл ажиллагааны хариуцлагыг "А" тал болон бусад этгээдийн өмнө бүрэн хариуцна.

6.2. Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс хамтын үйл ажиллагаа буюу нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд уг хохирлыг гэм буруутай тал нь хөрөнгөөрөө бүрэн хариуцан арилгах үүрэгтэй.

6.3. Талуудын аль нэг нь хамтын үйл ажиллагаатай холбоотой аливаа чухал шийдвэрлэх асуудлын талаар гэрээний нөгөө талд урьдчилан мэдэгдэж, бичгээр зөвшөөрөл авах ёстой.

6.4. Зайлшгүй зөвшөөрөл авах буюу хамтын шийдвэр гаргах асуудлыг зөвшөөрөл авалгүйгээр шийдвэрлэснээс үүдэн гарах аливаа хохирлыг дур мэдэн шийдвэрлэсэн 7.1. Гэрээ дараах үндэслэлээр дуусгавар болно.

7.1.1. Хамтын үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж, гэрээний хугацаа дуусгавар болсон;

7.1.2. Талууд гэрээг дуусгавар болгох тухай харилцан тохиролцсон

7.1.3. Гэрээний аль нэг тал хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр гэрээг цуцалсан 8.2. "А" тал нь үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа тогтоож өгөөгүй боловч үүрэг гүйцэтгэхийг "Б" талд урьдчилан сануулсан бол нэмэлт хугацаа тогтоосонтой адилтгаж үзнэ.

Найм. Гэрээ цуцлах

8.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

8.1.1. талуудын аль нэг нь итгэлийг алдсан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан;

8.1.2. талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ өөрөө биечлэн гүйцэтгээгүй буюу бусдад дур мэдэн шилжүүлсэн;

8.1.3. талууд гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа өөрийн буруугаас нөгөө талдаа эд хөрөнгийн ноцтой хохирол учруулсан, Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн;

8.1.4. Талууд хамтран ажиллах явцдаа олж мэдсэн мэдээ, мэдээллийг задруулсан, задруулахаар завдсан;

8.1.5. Хуульд заасан бусад үндэслэл.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ

- 8.2. "А" тал гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй, "Б" тал гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу гэрээнд харш үйл ажиллагаа явуулсны улмаас гэрээг цуцалсан бол "Б" тал санхүүжилт шаардах эрхээ алдана.
- 8.3. Энэ гэрээний 9.1-д заасан нөхцлөөс өөр үндэслэлээр гэрээ цуцлах тохиолдолд талууд нөгөө талдаа гэрээний хугацаа дуусахаас өмнө нэг сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэнэ.
- 8.4. Талуудын удирдлага өөрчлөгдсөн нь гэрээ цуцлах үндэслэл болохгүй.

Ес. Бусад зүйл

- 9.1. Гэрээ нь талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, батлах эрх бүхий албан тушаалтан батлаж, тамга дарснаар хүчинтөгөлдөр болно.
- 9.2. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт, өөрчлөлтийг талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж гэрээнд хавсаргана
- 9.3. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 9.4. Хэрэв санал зөрөлдөөнийг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй бол хууль тогтоомжид заасны дагуу /шүүх, арбитра/-аар /доогуур зурах/ шийдвэрлүүлнэ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"А" талыг төлөөлж:
ХАБЭА-н инженер... М.Баярсайхан
Хаяг: Говь-алтай, ДС-н барилга байгууламжын талбай
ӨЗМТөв
Утас: 99091211

"Б" талыг төлөөлж:
Дарга... О. Биндэръяа
Хаяг: "Энх-Алтай"
Утас: 99723300
70484580

Хөрс агаарын шинжилгээний хариу

БОШЛабораторийн тоос, тоосонцрын шинжилгээний дүн

Дугаар он/№ : 2023/ 1
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Энерготех сервис" ХХК
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн техникч С.Янжмаа
 Дээжийн тоо, төрөл : 3.Тоос
 Хүлээн авсан огноо : 2023.9.25
 Дээжийн тодорхойлолт : Дулааны цахилгаан станц
 Шинжилсэн огноо : 2023.9.29
 Хуудасны тоо : 1/1

Агаар бохирдуулагч бодис	PM10 _{мг/м³}
Дундаж	0.064
Их	3.05
Бага	0.014
MNS 4585:2016	0.100

Агаар бохирдуулагч бодис	PM2.5 _{мг/м³}
Дундаж	0.076
Их	1.12
Бага	0.014
MNS 4585:2016	0.50

Агаар бохирдуулагч бодис	PM Нийт тоос _{мг/м³}
Дундаж	0.061
Их	1.28
Бага	0.014
MNS 4585:2016	0.150

УЦУОШТ-ийн дарга: Н.Алтантуяа



Хөрс агаарын шинжилгээний хариу

БОШЛабораторийн агаарын шинжилгээний дүн

Дугаар он/№ : 2023/01
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Энерготех сервис" ХХК
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн техникч С.Янжмаа
 Дээжийн тоо, төрөл : Агаар-1
 Хүлээн авсан огноо : 2023.9.25
 Дээжийн тодорхойлолт : Дулааны цахилгаан станц
 Шинжилсэн огноо : 2023.9.29
 Хуудасны тоо : 1/1
 Үр дүн

Өдөр	Даралт.мм	Температур.С ⁰	Чийг	Салхины зүг	Салхины хурд м/с	Салх ерөвхийл м/с
9.29	588.7	-7.9	75	Салихгүй	0	3

Агаар бохирдуулагч бодис	Хүхэрлэг хий - SO ₂ мкг/м ³	Азотын давхар исэл NO ₂ мкг/м ³
Дундаж	34	57
MNS 4585:2016	450	200

Баталгаажуулсан:
 УЦУОШТ-ийн дарга..... Н.Алтантуяа
 Хянасан:
 БОШЛ-ийн эрхлэгч..... Д.Сарантуяа

Хөрс агаарын шинжилгээний хариу

БОШЛабораторийн хөрсний агрохимийн шинжилгээний дүн

: 2023/ 11
 р, хаяг, утас : "Энерготех сервис" ХХК
 бан тушаал : БОШЛ-ийн техникч С.Янжмаа
 : 2.хөрс
 : 2023.09.29
 : 2 цэгийн хөрсний сорьц
 : 2023.10.2-5
 : 1/1

	Уртраг	Өргөрөг	Ялзмаг %	pH	Чийг %	NH ₄ мг/кг	NO ₃ мг/кг	P мг/кг	SO ₄ мг/кг
	96°15'65.8"	46°21'24.8"	0.22	7.98	0.54	8.97	14.544	8.823	4108.0
	96°15'58.6"	46°21'23.4"	0.37	7.92	1.36	10.60	56.358	6.565	2076.0
Ө							130		160

БАТАЛГААЖУУЛСАН: УЦУОШТөвийн дарга

/Н.Алтантуяа/





ХЯНАСАН: ЦУОТХэлтсийн дарга

/Т.Дэлгэрмаа/

ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: БОШЛ-ийн эрхлэгч

/Д.Сарантуяа/

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ

1	Төслийн талбайн орчны хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, хяналт тавьж байна.	
2	Галын аюулгүй байдлыг хангаж MNS 5566:2020 стандартын дагуу В ангиллын галын сарайг хийж байршуулсан. Мөн шаардлагатай газруудад галын хор байршуулсан.	
3	Шимт хөрсийг хуулан авч тусгай овоолгын талбайд хадгалж байна.	
4	Бараа материал ачсан тээврийн хэрэгсэл болон, төслийн талбайд нэвтэрч буй тээврийн хэрэгслийг заасан маршрутын дагуу зорчуулж, зогсоолд байршуулж байна.	

<p>5</p>	<p>Хог хаягдлыг ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээг хийж, савыг ангилан байршуулсан.</p>	
<p>6</p>	<p>Ахуйн хатуу хог хаягдлыг хадгалах тусгай хогийн цэг байршуулсан.</p>	
<p>7</p>	<p>Хөрсний хэт халалтай , хуурайшилттай байсан тул аймгийн онцгой байдалтай хийсэн гэрээний дагуу 7 ,9 саруудад 3 удаа усалгаа хийлгэв.</p>	
<p>8</p>	<p>Тээврийн хэрэгслээс ШТМ асгарахаас сэргийлж шингээх материал худалдан авах захиалга хийсэн.</p>	<p>ШТМ асгарахаас сэргийлж шингээх материалын багц худалдан авч, нөөцийг бүрдүүллээ.</p>

9	Барилгын ажилд ашиглаж байгаа техникийг хуваарийн дагуу үзлэгт оруулж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна.	2023 оны 5 сард төлөвлөгөөт засварт орсон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх асгаралт гоожилт бүртгэгдээгүй.
10	Харъяа өрхийн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, яаралтай үед түргэн тусламж үзүүлэх болон амбулаторын үзлэгтхамрагдах боломжоор ханган ажиллаж байна.	Хамтран ажиллах гэрээг хавсралтаар оруулсан.
11	Төслийн талбайгаас гарч буй хог хаягдлыг тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн зориулалтын хогийн цэгт хаяж байна.	Хот тохижилт үйлчилгээний газартай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.
12		